МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 30 өдөр Дугаар 13 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх хэсгийг үндэслэн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд **ТОГТООХ нь:**

1. Монгол улсын Шинжлэх ухааны Академийн шагналууд ба тэдгээрийг олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. ШУА-ийн Хубилай хаан алтан медалийн загварыг нэгдүгээр хавсралт, үнэмлэхийн загварыг хоёрдугаар хавсралт, ШУА-ийн Хүндэт докторын өмсгөлийн загварыг гуравдугаар хавсралт, дипломын загварыг дөрөвдүгээр хавсралт, ШУА-ийн шилдэг судлаачийн өргөмжлөлийн загварыг тавдугаар хавсралт, ШУА-ийн шилдэг залуу судлаачийн өргөмжлөлийн загварыг зургадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Журмыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан ШУА-ийн Тэргүүлэгчдийн 1998 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан Эрдэм шинжилгээний тэргүүний залуу ажилтан шалгаруулах журам, ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2001 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсан Монгол улсын Шинжлэх ухааны Академийн шагнал олгох журам, ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2004 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан Монгол улсын Шинжлэх ухааны Академийн “Хүндэт гишүүн” (Хүндэт доктор) цол олгох журмыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Д.РЭГДЭЛ

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.АВИД

ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ..13.. тоот тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ШАГНАЛУУД БА ТЭДГЭЭРИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Төрөөс шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан технологи инновацийн салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт идэвхи зүтгэл үр бүтээлтэй ажиллаж, үнэтэй хувь нэмэр оруулсан, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан эрдэм шинжилгээний ажилтан, салбарын албан хаагч, Монгол улсын иргэн, гадаад улсын иргэнийг Шинжлэх ухааны Академийн шагналаар /цаашид "Академийн шагнал" гэх/ шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Журмын зорилго нь ШУА-ийн шагналын төрөл, дагалдах мөнгөн шагналын хэмжээ, шагнал олгох зарчим, нөхцлийг тогтоох, шагналд тодорхойлох болон шийдвэрлэх, шагналтай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

1.3 Шагналыг ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар олгоно.

Хоёр. Шагналын төрөл

2. Шинжлэх ухааны Академи дор дурдсан шагналтай байна.

2.1.1 "Хубилай хаан" медаль;
2.1.2 "ШУА-ийн Хүндэт доктор" цол;
2.1.3 "ШУА-ийн шилдэг судлаач" өргөмжлөл;
2.1.4 "ШУА-ийн шилдэг залуу судлаач" өргөмжлөл;
2.1.5 "ШУА-ийн Хүндэт жуух бичиг".

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүн нь олон улсын хэмжээнд үнэлэгдсэн, шинжлэх ухааны салбарт 20-иос доошгүй жил ажилласан, шинжлэх ухааны нарийн мэргэшлийн боловсон хүчин бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан мэргэжлийн өндөр ур чадвартай Монгол улсын болон гадаадын эрдэмтэн мөн Монгол улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан төрийн зүтгэлтэн, хувь хүнийг Монгол улсын Шинжлэх ухааны Академийн дээд шагнал "Хубилай хаан" медалиар шагнаж, үнэмлэх олгоно.

3.1.1. Үнэмлэх нь дараах загвартай байна (Хавсралт 1);
3.1.2. Шагналыг их хаан Хубилайн төрсөн өдөр болон Шинжлэх ухааны Академи байгуулагдсан өдрийг тохиолдуулан жилд 2 удаа ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулж нийтдээ Монгол улсын 2 хүртэл, гадаад улсын 2

хүртэл хүнд олгоно;

3.1.3. Шагналд ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаас нэр дэвшүүлнэ.

3.2. Шинжлэх ухааны тодорхой салбар, чиглэлийг үүсгэн хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан, судалгааны үр дүн нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хэрэглээнд нэвтэрсэн Монголын эрдэмтэн судлаач, манай эрдэмтэдтэй хамтран өндөр үр бүтээлтэй олон жил ажилласан, эсвэл Монгол улсын шинжлэх ухааны хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан гадаадын эрдэмтэнд ШУА-ийн Хүндэт доктор цол олгоно.

3.2.1. Хүндэт доктор цолыг диплом, энгэрийн тэмдэг дагалдана (Хавсралт 2);

3.2.2. Шагналыг Монгол улсын 4 хүртэл эрдэмтэнд шинжлэх ухааны ажилтны өдрөөр, гадаад улсын 4 хүртэл эрдэмтэнд тухай бүр олгож байна;

3.2.3. Шагналд эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлөөс нэр дэвшүүлж, ШУА-ийн удирдах ажилтнаас бүрдсэн ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргана.

3.3. ШУА-ийн харьяа хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтны судалгааны ажлын онол арга зүйн түвшин, хэрэглээний ач холбогдол, үр дүн, олон улсын хэмжээнд үнэлэгдсэн байдал зэргийг харгалзан жилд нэг эрдэмтнийг ШУА-ийн Шилдэг судлаачаар өргөмжилнө..

3.3.1. Шилдэг судлаачийн өргөмжлөлийг 1500 000 (нэг сая таван зуун мянган) төгрөг дагалдана;

3.3.2. Шагналыг Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан олгоно;

3.3.3. Шагналд харъяа хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөс дэвшүүлж, Тэргүүлэгчдийн газрын ажлын хэсэг дүгнэлт гаргана. Мөн ШУА-ийн ерөнхийлөгч нэр дэвшүүлж болно.

3.4. ШУА-ийн харьяа хүрээлэнгийн залуу эрдэм шинжилгээний ажилтны мэргэжлийн ур чадвар, судалгааны ажлын үр дүн, хэрэглээний өгөөжийг харгалзан жилд 1 удаа 40 хүртэлх насны нэг эрдэм шинжилгээний ажилтныг ШУА-ийн Шилдэг залуу судлаачаар өргөмжилнө.

3.4.1. Шилдэг залуу судлаачийн өргөмжлөлийг 1000 000 (нэг сая) төгрөг дагалдана;

3.4.2. Шагналыг Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан олгоно;

3.4.3. Шагналд харъяа хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөс дэвшүүлж, Тэргүүлэгчдийн газрын ажлын хэсэг дүгнэлт гаргана. Мөн ШУА-ийн ерөнхийлөгч нэр дэвшүүлж болно.

3.5. Боловсрол, шинжлэх ухааны салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил үр бүтээл, идэвхи санаачилгатай ажиллаж, эрдэм шинжилгээ судалгааны ажилдаа тодорхой амжилт гаргасан дотоод, гадаадын судлаачид болон ажилтан албан хаагчдыг тухайн байгууллагын 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тэгш ой болон салбарын тэмдэглэлт өдөр, Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан ШУА-ийн Хүндэт жуух бичгээр шагнана.

3.5.1. ШУА-ийн Хүндэт жуух бичгийг 50 000 (тавин мянган) төгрөг дагалдана;

3.5.2. Шагналыг Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан олгоно;

3.5.3. Шагналд тухайн байгууллагын хамт олны хурлаас нэр дэвшүүлж, Тэргүүлэгчдийн газрын ажлын хэсэг дүгнэлт гаргана. Мөн ШУА-ийн ерөнхийлөгч нэр дэвшүүлж болно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэхэд дагалдах материал

4.1 Шагналд тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлэн тогтсон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар ирүүлнэ. Шагналын материалыг хугацаа хожимдуулсан, дутуу бүрдүүлсэн тохиолдолд хүлээн авахгүй бөгөөд тухайн байгууллагад буцаана.

4.2.1. Шагналын анкет;

4.2.2. Ажил байдлын тодорхойлолт;

4.2.3. Ажлын үр дүнгийн үзүүлэлт /бүтээлийн жагсаалт/;

4.2.4. Хамт олны хурлын тэмдэглэл;

4.2.5. Шагналд нэр дэвшүүлсэн тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг.

4.3. Шагналд нэр дэвшүүлсэн материалыг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагнал олгохгүй.

Тав. Шагналыг олгох зарчим, нөхцөл

5.1. ШУА-ийн шагналын нэр хүндийг хадгалж, шагналыг оновчтой олгох зорилгоор ШУА-ийн Орлогч дарга болон холбогдох хэлтэс, нэгж ирүүлсэн материалыг хянаж, саналаа удирдлагад урьдчилан танилцуулна.

5.2. Шагнагдсан хүн өөрийн биеэр хүрэлцэн ирээгүй тохиолдолд тухайн шагналыг тодорхойлсон байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

5.3. ШУА-ийн шагналаар шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгохгүй.

5.4. Шагналын материалыг буцаан олгохгүй.

5.5. Мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, тухайн оны шагналын материалыг архивт шилжүүлэх ажлыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын Дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн эрхэлнэ.

---oooOooo---